



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/500

Хэрлэн сум


“Хэнтий аймгийн статистикийн  
эмхэтгэл” ном хэвлүүлэхэд хөрөнгө  
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Хэнтий аймгийн 100 жилд зориулан “Хэнтий аймгийн статистикийн эмхэтгэл” ном хэвлүүлэх зардалд 1,880,000 (нэг сая найман зуун наян мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага иргэдээс тависан хүсэлт зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ